



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын нэр: "Орон нутгийн 2017 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр ашиг" гүйцэтгэлийн аудит

Аудитын код: ГАГ- ХӨА-2018-01-ГА

### Чулууны үйлдвэр



Төсөвт өртөг :  
386,4 сая төгрөг

Гүйцэтгэгч:  
"Тэмээн" ХХК

*Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалын дагуу гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудит*

### RO ус цэвэршүүлэх систем



Төсөвт өртөг:  
30.0 сая төгрөг

Гүйцэтгэгч:  
"Айвико" ХХК

**ТАХ-г төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаалан төсвийн хөрөнгө үр дүн, үр ашиггүй зарцуулагдах нөхцлийг бий болгож, улмаар зөрчлүүд жил бүр давтагдан гардаг болжээ.**

### Үерийн ус зайлуулах байгууламж



Төсөвт өртөг:  
56.0 сая төгрөг

Гүйцэтгэгч:  
"Хөвсгөл АЗЗА"  
ХХК

**Мөрөн 2018 он**



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОРЫН ТУШААЛ**

2018 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/20

Мөрөн сүм

**Аудитын тайлан баталгаажуулах тухай**

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаал, 2017 оны А/188 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.40 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу “Орон нутгийн 2017 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Л.Төмөрбаатар), Засаг дарга (Л.Ганболд), Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир), Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд), Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга (Ч.Уртнасан), Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга (В.Нэргүй) нарт зөвлөсүгэй.

5. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер (Г.Эрдэнэчимэг), ахлах аудитор (Ж.Отгончимэг) нарт даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ГАНБОЛД

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын Өргийн байгуул  
аудиторын 2018 оны 05 дугаар сарын 09 өдөр хийсэн  
А/20 дугаар тушаалын 2 тусгай үйлчилгээний



**ОРОН НУТГИЙН 2017 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГТ ХИЙСЭН  
АУДИТААР ӨГӨГДСӨН АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ**

Д/д	Зөрчил хариуцагч байгууллага	Албан шаардлагын дугаар	Өгсөн ажилтан	Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дүн /мянган төгрөгөөр/
1	Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ	01/21	Ахлах аудитор	Гэрээний хугацаанд төсөл, арга хэмжээг хэрэгжүүлээгүй.	8000.0
2	Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ	02/22	Ж.Отгончимэг, аудитор Б.Сандуйжав		10000.0
<b>Нийт дүн</b>					<b>18000.0</b>

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

## АГУУЛГА



Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь  
Төрийн Аудитын газар

Тэргүүлэх аудитор

О.Ганболд

Аудитын менежер

Г.Эрдэнэчимэг

Ахлах аудитор

Ж.Отгончимэг

Аудитор

Б.Сандуйжав

2018 оны 05 дугаар  
сар

Уг тайланг УАГ-ын Веб  
сайт-аас үзнэ үү.

[www.audit.mn](http://www.audit.mn)

Аудитын тайлан,  
дүгнэлттэй холбоотой  
асуудлаар нэмж  
тодруулах, асууж  
лавлах зүйл байвал  
70384043 дугаарын  
утас, 70383793  
дугаарын факсаар  
харилцана уу?

**ХАЯГ:** (Хөвсгөл  
аймгийн ЗДТГ-ын А  
байр 3 давхарт)

Товчилсон үгийн тайлбар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

**Ерөнхий зүйл**

**БҮЛЭГ-1. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй төсөл, арга хэмжээг баталсан байна.**

1.1. Зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг баталсаар байна.

1.2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хуулийн шаардлагад нийцүүлж төлөвлөөгүй байна.

**БҮЛЭГ-2. Худалдан авах ажиллагааг зохих журам зааврын дагуу үнэн зөв тайлагнасан эсэхэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.**

2.1. Худалдан авах ажиллагаа ил тод хурдан шуурхай зохион байгуулагдсан байна.

2.2. Засаг даргын захирамжаар үнэлгээний хороо байгуулсныг эс тооцвол: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

**БҮЛЭГ-3. Захиалагчийн хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.**

3.1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн албан хаагчдын ажлын уялдаа холбоо хангалтгүй, хариуцлага сулаас, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаагүй, улмаар зөрчил дутагдал давтан гарах нөхцөл бий болсон байна.

3.2. Захиалагчийн хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал ....

Хавсралт .....

Тайлангийн хураангуй.....

Тэргүүлэх аудиторовын тушаал .....

Албан шаардлага .....

## Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон үг	Тайлбар
<b>АДБОУС</b>	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
<b>ТБОНӨХБАҮХАТ</b>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
<b>ГАГ</b>	Гүйцэтгэлийн аудитын газар
<b>ГА</b>	Гүйцэтгэлийн аудит
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>ХОХБТХ</b>	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
<b>СТСХ</b>	Санхүү, төрийн сангийн хэлтэс
<b>ОНӨГ</b>	Орон нутгийн өмчийн газар
<b>ГХБХБГ</b>	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
<b>МХГ</b>	Мэргэжлийн хяналтын газар
<b>ТХОТСХТЖ</b>	Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам
<b>ОНХО</b>	Орон нутгийн хөрөнгө оруулалт
<b>ТЭЗҮ</b>	Техник, эдийн засгийн үндэслэл
<b>ХАА</b>	Худалдан авах ажиллагаа
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>ААН</b>	Аж ахуйн нэгж
<b>ТАХ</b>	Төсөл арга хэмжээ
<b>ХХҮГ</b>	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
<b>ОБГ</b>	Онцгой байдлын газар
<b>ЭМТ</b>	Эрүүл мэндийн төв
<b>СӨБ</b>	Сургуулийн өмнөх боловсрол

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

### **Аудитын зорилт**

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт үндэслэлтэй оновчтой байна уу?
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа үр дүнтэй байна уу?
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?

### **Аудитын хамрах хүрээ**

Аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн ИТХ, ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ, ОНӨГ, МХГ, ГХБХБГ, сумдын ИТХ болон ЗДТГ, холбогдох байгууллагууд, зарим гүйцэтгэгч ААН-ийн хүрээнд шалгалаа.

### **Аудитын арга зүй**

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын журмыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан байгууллага болон ОНӨГ-ын дарга болон холбогдох ажилтан албан хаагчидтай уулзаж санал солилцож, тайлбар гаргуулан, амаар зөвлөмж өгч, ГХБХБГ, ОНӨГ, ЗДТГ-ын СТСХ, ХОХБТХ-ийн гаргасан судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажиллалаа.

### **Шалгуур үзүүлэлтүүд**

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамжид заасны дагуу аудитын дүн дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Өрийн удирдлагын тухай хууль
- Сангийн Сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан ТХОТСХТ журам

- Сангийн Сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан ТБОНӨХБАҮХА ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам.
- Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан ТБОНӨХБАҮХА ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам.
- Аймгийн ИТХ-ын хуралдааны баталсан, тодотгосон тогтоолууд
- Холбогдох бусад хууль, журам, шийдвэр

#### **Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн**

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор О.Ганболд удирдан, аудитын менежер Г.Эрдэнэчимэг аудитын арга зүйгээр хангаж, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ж.Отгончимэг, аудитор Б.Сандуйжав нар гүйцэтгэв.

## Ерөнхий зүйл:

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 32 төсөл, арга хэмжээг 1372.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр, аймгийн замын сангийн хөрөнгөөр нийт 18 төсөл, арга хэмжээг 522.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тус тус баталсан<sup>1</sup> байна. Эдгээр төсөл, арга хэмжээг ангилж хүснэгт болон зураглалаар харуулбал:

Хүснэгт 1: ТАХ-ний ангилал

№	ТАХ-ний ангилал	Тоо	Тайлбар
<b>Орон нутгийн хөрөнгө оруулалт</b>			
1	Тайланд онд шинээр хэрэгжүүлсэн.	27	
2	Өмнөх онд хэрэгжсэн, тайлант онд үлдэгдэл санхүүжилт батлагдсан.	5	Төлөвлөлт, ХАА, гүйцэтгэлийн талаар өмнөх аудитад тусгагдсан болно.
<b>Аймгийн замын сан</b>			
1	Тайланд онд шинээр хэрэгжүүлсэн.	15	
2	Өмнөх онд хэрэгжсэн, тайлант онд үлдэгдэл санхүүжилт батлагдсан.	3	Төлөвлөлт, ХАА, гүйцэтгэлийн талаар өмнөх аудитад тусгагдсан болно.
	<b>Нийт</b>	<b>50</b>	

Зураглал 1:



<sup>1</sup> Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит 3 дугаар хуралдааны 03 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын 2017 оны ээлжит 5 дугаар хуралдааны 05 дугаар тогтоол.



## Бүлэг 1: Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй төсөл, арга хэмжээг баталсан байна.

### Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг баталсаар байна.

1.1. Орон нутгийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр тайлант онд шинээр хэрэгжүүлсэн 41 төсөл, арга хэмжээнээс 7 нь аймгийн 2017-2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Хөвсгөл аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг баримт, бичигт тусгасан зорилт, арга хэмжээтэй уялдаагүй байна. Эдгээр төсөл, арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт 2: Бодлогын баримт бичигт тусгагдаагүй төсөл, арга хэмжээ*

Төсөл, арга хэмжээний нэр, санхүүжүүлсэн эх үүсвэр			
№	Орон нутгийн хөрөнгө оруулалт	№	Замын сан
1	Фото альбом хэвлүүлэх	1	Хот тохижилт үйлчилгээний замын арчилгааны давс, цас хайлуулах бодис багаж, тоног төхөөрөмж худалдан авах
2	Бензин бага зарцуулдаг машин худалдаж авах /МХГ-т/	2	Түнэл сумын Хасагийн дөрөлжийн давааны зам засвар
3	Ахмадын өргөөний барилга барих /Галт сум/	3	Мөрөн сумын төв 4 зам, аюулгүйн тойргийн 4 замын уулзварын гэрлэн дохио засварлах ажил
4	Спорт заалны барилга шинээр барих /Эрдэнэбулган сум/		

Хүснэгтэд харуулсан замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний тухайд: Аймгийн 2017-2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрт “2017 онд авто замын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх” гэж заасан ч уг төлөвлөгөөний хугацаа 2016 онд дууссан, дахин боловсруулаагүй байна.

Дээрх төсөл арга хэмжээнүүдийг төлөвлөх, тухайн санхүүгийн жилийн төсөлд тусгахдаа ТХОТСХТ<sup>2</sup>-ын журмын 3.1.болон 3.6<sup>3</sup>-д заасан зарчмыг баримтлаагүй байна.

1.2. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 40.4 хувь нь барилга, байгууламжийн засвар, 21.4 хувь нь тоног төхөөрөмж, 16.6 хувь нь барилга байгууламж барих, 21.6 хувь нь бусад арга хэмжээ байна.

1.3. Өмнөх оноос дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг батлахдаа нөөцийг бодитой хуваарилсан байна. Эдгээр төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлээгүй ч төсөл, арга хэмжээний эхлэх, дуусах хугацаа өмнөх оны тогтоолд баталсан хугацаанаас зөрүүтэй баталсан байна.

1.4. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээнд ТЭЗҮ хийгдээгүй байна. Энэ нь МУ-ын “Төсвийн тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4<sup>4</sup>, ТХОТСХТ-ын журмын 3.2<sup>5</sup>-г зөрчсөн байна. ТЭЗҮ хийгдээгүй төсөл, арга хэмжээг Хавсралт 1-ээс харна уу.

<sup>2</sup> Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан журам

<sup>3</sup> 3.6. Төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг нийслэлийн тухайн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь тухайн захиалагчийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр /УХОЖ/-тэй харилцан уялдсан байхын зэрэгцээ салбарын гол тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтын ач холбогдол, тухайн төслийн хэрэгжилттэй уялдуулан эрэмбэлсэн байна.

<sup>4</sup> 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

<sup>5</sup> ТХОТСХТЖ-ын 3.2. Тухайн санхүүгийн жилд эхлүүлэхээр төлөвлөж буй барилга байгууламж нь 3.1.-т заасан зарчмыг баримталсан байхын зэрэгцээ инженер хайгуулын судалгааг хийж, дүгнэлт гаргасан, зураг төслийг экспертизээр батлуулсан, барилга барих газар болон инженерийн шугам, сүлжээний асуудлыг бүрэн шийдсэн, үр ашигтай нь техник, эдийн засгийн



1.5. Зарим төсөл, арга хэмжээний зураг, төсөв нь аймгийн ИТХ-ын хуралдаанаар баталснаас хойш хийгдсэн байна. Энэ нь: “Төсвийн тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журмын 5-г тус тус **зөрчсөн үйлдэл** болсон байна. Өмнөх оны аудитаар уг зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн ч биелүүлээгүй байна. Дээрх зөрчилтэй төсөл, арга хэмжээг дурдвал:

- Чулууны үйлдвэр /2017 оны 06 сард зураг, төсөв нь хийгдсэн, 2017.07.02-нд хянан баталгаа хийгдсэн/
- Орон сууцны байруудын хэрэглээний халуун усны шугамыг өргөтгөх /2017 онд зураг нь хийгдсэн, 2017.12-нд зураг, төсөвт хянан баталгаа хийгдсэн.
- Жаргалант сумын соёл, спортын төвийн барилга шинээр барих /2017.06-нд зураг, төсөв нь хийгдсэн, 2017.07-нд зураг, төсөвт хянан баталгаа хийгдсэн/
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Эрчим ахмадын амралтын сувиллын засвар, өргөтгөлийн ажлын дуусгалт /Хатгал тосгон/ /2017.08-нд зураг, төсөв нь хийгдсэн, 2017.10-нд хянан баталгаа хийгдсэн/
- Мөрөн сумын 4-н замын 2 уулзварт гэрлэн дохио суурилуулах /2017 онд зураг, төсөв нь хийгдсэн, 2017.06-нд хянан баталгаа хийгдсэн/
- Мөрөн сумын 1-р багийн авто зам дагуу гудамжны ус зайлуулах байгууламж барих /2017 онд зураг, төсөв нь хийгдсэн, 2017.07-нд хянан баталгаа хийгдсэн/
- Тариалан сумын Шивэртийн давааны зам засвар /2017 онд зураг, төсөв нь хийгдсэн, 2017.07-нд хянан баталгаа хийгдсэн/
- Түнэл сумын Хасагийн дөрөлжийн давааны зам засвар /2017 онд зураг, төсөв нь хийгдсэн, 2017.07-нд хянан баталгаа хийгдсэн/

**Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хуулийн шаардлагад нийцүүлж төлөвлөөгүй байна.**

1.5. Орон нутгийн төсвөөр 2017 онд хэрэгжүүлэх зарим нэгэн төсөл арга хэмжээнд хөрөнгө оруулалтын бус шинж чанартай болон улсын төсвийн байгууллагад хөрөнгө оруулалт хийх зэрэг ажлыг төлөвлөжээ. Үүнд: /хүснэгтээр харуулбал/

*Хүснэгт 3: Хөрөнгийн шинж чанаргүй, улсын төсвийн байгууллагад хөрөнгө оруулалт хийсэн төсөл, арга хэмжээ*

/сая.төг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Санхүүжсэн дүн	Тайлбар
1	ОБГазрын барилгын гадна дулааны ажил	159,0	109,7	Төрийн өмч
2	МХГ-т бензин бага зарцуулдаг машин	10,0	10,0	Төрийн өмч
3	Хилийн заставын ажилчдын СӨБ-ын хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн	8,0	8,0	Хөрөнгийн шинж чанар агуулаагүй
4	Фото альбом хэвлүүлэх	30,0	8,0	Хөрөнгийн

үндэслэл, тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажлыг эхлүүлэх нөхцлийг хангасан, урсгал зардлын урьдчидсан тооцоо хийгдсэн байна.

				шинж чанар агуулаагүй, төсөвт өртөг болон ажлын даалгавар тодорхой бус
5	Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө	10,0	10,0	Хөрөнгийн шинж чанар агуулаагүй
6	Хот тохижилт үйлчилгээний замын арчилгааны давс, цас хайлуулах бодис багаж, тоног төхөөрөмж худалдан авах	9,0	9,0	Хөрөнгийн шинж, чанар агуулаагүй
<b>Нийт</b>		<b>226,0</b>	<b>154,7</b>	

Дээрх төсөл арга хэмжээнүүд нь МУ-ын “Төсвийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24, 4.1.27<sup>6</sup>, 6 дугаар зүйлийн 6.6.5, 6.6.6-д заасан заалтад нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл: Төсөл арга хэмжээг төлөвлөхдөө тухайн ажлыг хариуцдаг төрийн албан хаагч нь хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

1.6. Хоёроос дээш санхүүжилтийн эх үүсвэртэй төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлахдаа төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийг нэг эх үүсвэрийн дүнгээр баталсан **зөрчил** гарсан байна. **Тухайлбал:**

Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн барилгын их засвар, Баянзүрх сумын сургуулийн 75 хүүхдийн дотуур байрны засварлах ажил, Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа “Эрчим” ахмадын амралт сувилалд засвар, өргөтгөл барих зураг төсөл боловсруулах, угсралт, тохируулга хийх ажлуудын төсөвт өртгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх дүнгээр баталсан байна. Энэ нь тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ТХОТСХТ-ын журмын 4.21<sup>7</sup> дэх заалтыг зөрчсөн үйлдэл байна. Олон эх үүсвэртэй төсөл, арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4: Олон эх үүсвэртэй төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр, төрөл	Санхүүжилтийн эх үүсвэр					
		Улсын төсвийн хөрөнгө оруулалт (сая.төг)		Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт (сая.төг)		Байгууллагын урсгал зардал (сая.төг)	
		Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Батлагдсан төсөв	Гэрээн ий дүн
1	Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн барилгын их засвар	150.0	150.0	207.0	125.9		
2	Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны соёлын төвийн дээврийн засварын ажил	20.0	19.9	10.0	7.5		
3	Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа “Эрчим” ахмадын амралт	400.0	400.0	300.0	251.3		

<sup>6</sup> 4.1.24.“хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

4.1.27.“орон нутгийн төсөв” гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг;

<sup>7</sup> 4.21.Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно.

	сувилалд засвар, өргөтгөл барих зураг төсөл боловсруулах, угсралт, тохируулга хийх ажил						
4	Баянзүрх сумын сургуулийн 75 хүүхдийн дотуур байрны засварлах ажил			68.0	59.6	20.0	20.0
5	Цэцэрлэгийн барилгын засвар /Төмөрбулаг сум/	15.0	15.0	10.0	8.3		

**Бүлэг 2: Худалдан авах ажиллагааг зохих журам, зааврын дагуу үнэн зөв тайлагнасан эсэхэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.**

**Худалдан авах ажиллагаа ил тод хурдан шуурхай зохион байгуулагдсан байна.**

2.1. Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны худалдан авах төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Хурлын 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит IV дүгээр хуралдааны 4 дүгээр тогтоолоор баталсан байна. Харин эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж ажиллаагүй байна. Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” -ын 2 дугаар зүйлийн 2.7<sup>8</sup>-д заасан заалтыг зөрчсөн үйлдэл болсон байна.

2.2. Аймгийн Засаг дарга замын сан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнээс 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэг, засвар үйлчилгээ” төсөл, арга хэмжээний эрхийг Мөрөн сумын Засаг даргад шилжүүлсэн байна.

Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу үр дүнтэй зохион байгуулсан байна.

2.3. Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2017 онд аймгийн Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 13 төсөл, арга хэмжээ, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 27 төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан байна.

2.4. Аймгийн Засаг дарга Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах<sup>9</sup> тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1.1, Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаал, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн худалдан авалт зохион байгуулах тухай бүр “Үнэлгээний хороо”-г байгуулан ажилласан байна. Энэ нь “хуулийн” 45 дугаар зүйлийн 45.2.2<sup>10</sup> дах заалттай нийцэхгүй байна. **Тодруулбал:**

<sup>8</sup> 2.7. Захиалагч төсвийн тодотгол хийхэд ХАА-ны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Энэ тодотголд тухайн жилийн явцад шинээр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах, түүнийг санхүүжүүлэх буюу шинээр төсөл, арга хэмжээ эхлүүлэх шийдвэрийн хүрээнд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг тусгана. Тодотгосон төлөвлөгөөг журмын 2.6., 2.9.-д заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

<sup>9</sup> Цаашид хуулийн гэх

<sup>10</sup> 45.2.2. аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн орон нутагт худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагч нь байна.

**Тухайн орон нутагт худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагч нь аймгийн ЗДТГ-ын дарга юм.**

2.5.Тайлант онд худалдан авах үйл ажиллагааг “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”<sup>11</sup>-ыг баримтлан цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.

2.6. Тухайн байгуулагдсан “Үнэлгээний хороо”- нь тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж, баталгаажсан хувийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч хуулийн этгээдэд тарааж, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Босго үнэ батлах тухай”, Сангийн сайдын 2013 оны 84 дүгээр тушаалаар баталсан “Цахим сүлжээнд, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”-ыг тус тус баримтлан тендер шалгаруулалтын зар, үр дүнг худалдан авах ажиллагааны цахим хуудас /www.e-procurement.mn/-нд байршуулж, мэдээлж ажилласан байна.

**Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа холбогдох хууль болон журмын дагуу ажилласан бөгөөд ХАА-ны журмыг зөрчсөн асуудал байхгүй байна.**

Эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайд 2 санал гомдол гарсан бөгөөд худалдан авах ажиллагаатай холбоотой санал гомдлыг Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрээр Хөвсгөл аймгийн ОНӨГ-ын шийдвэр хуульд нийцсэн гэж үзсэн байна. Үүнд:

- 2017 онд улсын төсвийн 970,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хөвсгөл аймгийн Галт сумын сургуулийн спорт заалны барилгын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийн талаар “Урагшлах” ХХК-иас Сангийн яаманд гомдол гаргасан бөгөөд Сангийн яамны 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 6-1/4203 дугаар албан бичгээр худалдан авах ажиллагааны шийдвэр хуульд нийцсэн байна гэж мэдэгдсэн байна. Гэсэн хэдий ч “Урагшлах” ХХК нь Сангийн яамны дүгнэлтийг эс зөвшөөрч Хөвсгөл аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүх болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд тус тус хандсан бөгөөд шүүхийн шийдвэр Хөвсгөл аймгийн ОНӨГ-ын шийдвэрийг хуульд нийцсэн гэж үзсэн байна.
- “Мөрөн сумын эрдмийн далай цогцолбор сургуулийн “Б” байрны барилгын сантехникийн засвар”-ын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендер шалгаруулалтын талаар “Уул өвгөд” ХХК Сангийн яаманд гомдол гаргасныг Сангийн яам 2017 оны 6-1/4194 дүгээр албан бичгээр “худалдан авах ажиллагааны шийдвэрийг хуульд нийцсэн байна” гэж мэдэгдсэн байна.

Аймгийн ОНӨГ-ын зохион байгуулсан худалдан авах үйл ажиллагаа ил тод, шуурхай явагдсан гэж үзэж байна.

**Засаг даргын захирамжаар үнэлгээний хороо байгуулсныг эс тооцвол: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.**

2.7. Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан “Үнэлгээний хороо”- нь хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна. Худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг өмнөх онтой харьцуулж хүснэгтээр харуулбал: /тоогоор/

<sup>11</sup> МУ-ын Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар баталсан журам  
ГАГ-ХӨА-2018-01-ГА

Хүснэгт 5: Худалдан авах ажиллагааг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт

№	Эх үүсвэр	Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалтын арга		Шууд худалдан авалт		Хязгаарлагдмал	
		2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017
1	Орон нутгийн хөрөнгө оруулалт	1	11	4	16	1	0	0	0
2	Замын сангийн хөрөнгө	2	1	3	10		0	0	2
	Нийт	8	12	12	26	1	0	0	2

2.8. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6830,1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 31 төсөл арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж 398,8 сая төгрөгийн тендерийн хэмнэлт буй болгосон байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр хэрэгжих нийт 6711,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 41 төсөл арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж 511,9 сая төгрөгийн тендерийн хэмнэлт буй болгосон байна.

2.9. Худалдан авах ажиллагаанаас бий болсон хэмнэлтийг Орон нутгийн өмчийн газар зарцуулдаггүй байна. Харин Төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхийн хүрээнд төсвийн дахин хуваарилалтаар батлагдан зарцуулагддаг байна. Тендерийн хэмнэлтийг эх үүсвэр тус бүрээр нь хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6: Тендерийн хэмнэлт /сая төгрөг/

№	Эх үүсвэр	Батлагдсан төсөвт өртөг	Шалгарсан төсөвт өртөг	Тендерийн хэмнэлт	Тендерийн тоо
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	6830,1	4143,3	398,8	31
	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	5666,1	5221,8	422,2	28
2	Замын сангийн хөрөнгө	1044,9	955,3	89,7	13
	Нийт дүн	13541,1	10320,4	910,7	72

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр худалдан авах үйл ажиллагааг батлагдсан төсвөөс 910,7 сая төгрөгийн хэмнэлттэй зохион байгуулсан байна.

2.10. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчилсөн асуудал гараагүй байна. Аймгийн ИТХ-ын баталсан 2017 онд бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний нэршил болон зориулалтыг өөрчилсөн асуудал гараагүй байна.

**Дээрх арга хэмжээнүүдийг зохион байгуулахдаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн холбогдох заалтууд, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах” журам, “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам” -ын дагуу зохион байгуулж ажилласан байна.**

2.11. Аймгийн ОНӨГ нь 2017 оны худалдан авах ажиллагааны тайланг бэлтгэж холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч болон Сангийн яаманд хүргүүлж ажилласан

байна<sup>12</sup>./Бүтэн жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус хүргүүлнэ./

2.12. Худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба<sup>13</sup> “89,6 хувь буюу хангалттай” гэж дүгнэсэн нь тус газрын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тодотгол хийгээгүй, тайлангийн тоон мэдээлэл зөрүүтэй зэргээс харахад **“Дүгнэлт бодит бус байна”** гэж гүйцэтгэлийн аудитаар үзэж байна.

2.13. Бид гүйцэтгэлийн аудитын явцад худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналын талаар мэдээлэл авах тусгайлсан маягт бэлтгэн аймгийн ОНӨГ-т хүргүүлж бэлтгүүлсэн боловч холбогдох мэдээ, судалгааг хангалтгүй бэлтгэн ирүүлсэн болно. /тоон мэдээлэл зөрүүтэй, тогтоосон хугацаанд ирүүлээгүй/

**Дээрх зөрчил, дутагдлаас харахад: Аймгийн ОНӨГ нь 2017 оны Худалдан авах ажиллагааг үнэн зөв, бодитой тайлагнаагүй байна.**

2.14. МУ-ын Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 4.1.-д (Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан үнэлгээний аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.) гэж журамласан байна.

**Гэсэн хэдий ч ЗДТГ-ын ХШҮДАХ- нь Худалдан авах ажиллагааг зохих журам, зааврын дагуу үнэн зөв тайлагнасан эсэхэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.**

2.15. ОНӨГ- нь мэдээ тайлангаа зөрүүтэй бэлтгэсэн, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үнэлгээ бодит бус, ХШҮДАХэлтэс нь холбогдох журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллаагүй зэргээс харахад ЗДТГ-ын хэлтэс, алба, мэргэжилтнүүдийн ажлын хариуцлага сул, ажлын уялдаа холбоо хангалтгүйгээс шалтгаалжээ.

### **Бүлэг 3: Захиалагчийн хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.**

**Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн албан хаагчдын ажлын уялдаа холбоо хангалтгүй, хариуцлага сулаас, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаагүй, улмаар зөрчил дутагдал давтан гарах нөхцөл бий болсон байна.**

3.1. 2017 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний биелэлт 83.3 хувьтай байна. Хэрэгжилтийн ерөнхий мэдээллийг Хавсралт 1-ээс харна уу. Хэрэгжиж дууссан ажлуудыг комисс хүлээн авч, ажлын гэрээг дүгнэсэн байна. Зарим төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэх гэрээний хугацаа дууссан ба одоог хүртэл гэрээгээ сунгаагүйгээс гэрээний хугацаа хэтрүүлсний алданги тооцох нөхцөл үүссэн байна. Хүснэгтээр харуулбал:

<sup>12</sup> Хөвсгөл аймгийн Засаг даргын 2018 оны оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 1/88 тоот

<sup>13</sup> МУ-ын Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.5.-д Худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланг дотоод аудит (дотоод аудитын нэгжгүй байгууллагын хувьд өөрийн байгууллагын дотоод аудитор)-аар хянуулж, холбогдох дүгнэлтийн хамт ирүүлнэ.

Хүснэгт 7: Хугацаа хэтрүүлсний алданги

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эх үүсвэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэгч
1	Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулах.	Орон нутгийн хөрөнгө оруулалт	10.0	Ногоон хөгжил аялал жуулчлал стратеги бодлого төлөвлөлтийн хүрээлэн
2	Фото альбом хэвлүүлэх.	Орон нутгийн хөрөнгө оруулалт	30.0	Итгэлт чандмань ХХК
<b>Нийт дүн</b>			40.0	

Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулах төсөл арга хэмжээний тухайд гэрээг сунгах хүсэлт ирүүлсэн ч одоогийн байдлаар сунгаагүй байна.

Фото альбом хэвлүүлэх төсөл, арга хэмжээний тухайд гэрээг сунгуулах хүсэлт ирүүлээгүй байна. 2017 оны санхүүжилтээр 8,0 сая төгрөг олгосон бөгөөд 22,0 сая төгрөгийн санхүүжилтийг 2018 оны төсөвт тусгаагүй байна.

Иймд: Гэрээний хугацаанд хэрэгжээгүй төсөл арга хэмжээг дуусгах **"Албан шаардлага"** хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.2. Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнд нийт 6699.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоор гэрээ байгуулснаас 1647.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

**Санхүүжүүлээгүй дүн нь: Зарим төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, зохиогчийн хяналт хийгдээгүй, магадлашгүй ажлын зардал гараагүй зэрэгтэй холбоотой байна. Мөн зарим төсөл, арга хэмжээний санхүүжилтийг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.**

Санхүүжилт нь дутуу болон олгогдоогүй төсөл, арга хэмжээний мэдээллийг **Хавсралт 1-ээс харна уу.**

3.3. Гэрээнд заасан нөхцлийн дагуу гүйцэтгэгч нарт санхүүжилтийг олгохдоо гэрээний үнийн дүнгийн 5 хувиар тооцон чанарын баталгаат хугацааны барьцаа хөрөнгийг “барьцаа хөрөнгө данс”-д байршуулсан байна.

3.4. 2017 онд чанарын баталгаат хугацаа нь дуусаж байгаа төсөл, арга хэмжээний барьцаа хөрөнгийг чөлөөлөхдөө Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4<sup>14</sup>-д заасны дагуу үзлэг хийж чөлөөлсөн байна.

3.5. Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс дараах төсөл, арга хэмжээний гүйцэтгэл **зөрчилтэй** байна. Үүнд:

- ХХҮГ-ын харьяа Эрчим ахмадын амралт сувиллын засвар, өргөтгөлийн ажлын дуусгалт: Уг барилга нь модон барилга бөгөөд балкыг өрөхдөө зай завсар ихтэй, хавчаар модыг дутуу хийсэн, дам нурууны хажуугаар зай ихтэй, балк хоорондын залгааг тэгшилж залгаагүй байна.

Зураг 1: “Эрчим” ахмадын амралт сувиллын засвар, өргөтгөл



<sup>14</sup> Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ.



**Захиалагч дээрх зөрчлийг аудитын хугацаанд /тайлагналын үе шатанд/ арилгуулан ажилласан байна. Барилгын ажил хэвийн явагдаж байна.**

Зураг 2: Зөрчил арилгуулсан байдал



- Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгыг засварлах ажлыг дуусгах: Өргөтгөл барилгын хүзүүвчийн паркетан шал хөдөлгөөнтэй, пар хагарсан тул ашиглалтгүй /1/, барилгын дотор талын ханын эслэг хавтангийн бэхэлгээ муутайгаас зай завсар гарсан, ус шахах үед хүчтэй дуу, чимээ гардаг.

Зураг 3: Хүүхдийн цэцэрлэгийн барилгын засвар



3.6. Дээрх зөрчлийг эс тооцвол: шинээр хэрэгжсэн төсөл арга хэмжээний хувьд ашиглалт сайн, ямар нэгэн зөрчил, дутагдалгүй байна. Эдгээр төсөл, арга хэмжээний хувьд захиалагч болон зохиогч хяналт тавьж ажилласнаар ажлын гүйцэтгэл үр дүнтэй болсон байна. Зургаар харуулбал:

Зураг 4: Үр дүнтэй хэрэгжсэн төсөл, арга хэмжээ.



Эх сурвалж: Нэгдсэн эмнэлгийн ус цэвэршүүлэгч

Мөрөн сумын 4 замын уулзварын гэрлэн дохио



Эх сурвалж: АЗДТГ-н соёмбо танхимын засвар

Нэгдсэн эмнэлгийн диализын өрөөний засвар

### **Захиалагчийн хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.**

3.7. Гэрээнд заасан нөхцлийн дагуу гүйцэтгэгч нарт санхүүжилтийг олгохдоо захиалагчийн хяналтын зардлыг “Захиалагчийн хяналтын зардал данс”-д байршуулсан байна.

3.8. Тайлант жилд захиалагчийн хяналтын зардлын дансанд нийт 221.7 сая төгрөгийн орлого төвлөрч, 65.3 сая төгрөгийн зарлага гарсан байна. Захиалагчийн хяналтын зардлын зарцуулалтыг шалгахад дараах **зөрчил** илэрлээ. Үүнд:

- Бээжин, Гуанжоу хотод үзэсгэлэн худалдаа, сургалтад оролцсон төрийн албан хаагчдын /аймгийн ЗДТГ, ОНӨГ-н албан хаагч, Мөрөн сумын багийн Засаг даргын бүрэлдэхүүнтэй/ зардалд 16.4 сая төгрөг зарцуулсан.
- Аймгийн ЗДТГ болон ОНӨГ-т нийт 16.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж авсан.

Аймгийн ОНӨГазар 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 1/351 дүгээр албан бичгээр “Манай газрын мэргэжилтнүүд ТБОНӨХБАУХАТ хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах, худалдан авах ажиллагааны баримт бичгийг архивлах, чиг үүргийг хэрэгжүүлж байна. Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны 1/1085 дугаар албан бичигт заасан зардлын ангиллыг орон нутагт шууд мөрдөх нь өрөөсгөл байна ...” гэсэн тайлбар ирүүлсэн байна.

ТБОНӨХБАУХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.2<sup>15</sup>-т хуулийн 46.1-д заасан эрхийг захиалагчийг төлөөлж төсвийн ерөнхий менежер хэрэгжүүлэхээр заасан байна. Хуулийн 46.3-д “Энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий этгээд энэ хуулиар өөрт олгогдсон эрхийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж болох боловч ийнхүү эрхээ шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан ч ерөнхий менежер аймгийн ОНӨГ-т энэхүү эрхийг шилжүүлээгүй атал тус газар нь захиалагчийн хяналтыг зарим нэгэн төсөл арга хэмжээн дээр хэрэгжүүлж байгаа нь хуулийн холбогдох заалт болон байгууллагын чиг үүрэгт нийцэхгүй үйлдэл болсон байна.

Дээрх зөрчилд дурдсан 16.4 сая төгрөгийг /Үзэсгэлэн худалдаа, сургалтад оролцсон/ зарцуулахаар гаргасан аймгийн Засаг даргын захирамж<sup>16</sup> нь Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны 1/1085 дугаар албан бичгийг үндэслэсэн байна.

Иймд: Аймгийн ОНӨГ нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч бус тул захиалагчийн хяналтын зардлаас дээрх арга хэмжээг санхүүжүүлэх нь үндэслэлгүй байна.

<sup>15</sup> Энэ хуулийн 4.1.1-д заасан захиалагчийг төлөөлж төсвийн ерөнхий менежер, 4.1.2-т заасан захиалагчийг төлөөлж гүйцэтгэх захирал энэ хуулийн 46.1-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

<sup>16</sup> 2017.10.06-ны А/665-р захирамж

**3.9. Гүйцэтгэлийн аудитаар нийт 10359.5 сая төгрөгийн /давхардсан дүнгээр/ алдаа зөрчил илэрч холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөмж<sup>17</sup> өгч ажилласан болно.**

## **ДҮГНЭЛТ**

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:**

1. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөхдөө ТХОТСХТ-ын журмын 3.1. болон 3.6.д заасан зарчмыг баримтлахгүй төлөвлөж, батлуулж байгаа нь тухайн чиг үүргийг хэрэгжүүлж, хяналт тавьж буй ЗДТГ-ын ХОХБТХ-ийн албан тушаалтнуудын ажлын хариуцлага сул, хариуцсан ажилдаа хайнга ханддагаас шалтгаалжээ.
2. Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт тусгагдаагүй, ТЭЗҮ, зураг, төсөв нь хийгдээгүй төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолоор баталсаар байна. Уг зөрчлийг арилгах зөвлөмжийг өмнөх онуудад хүргүүлсэн ч хэрэгжүүлж ажиллаагүй байна.
3. ОНӨГ нь 2017 оны Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг үнэн зөв бодитой тайлагнаагүй байна.
4. Худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба<sup>18</sup> “89,6 хувь буюу хангалттай” гэж дүгнэсэн нь тус газрын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тодотгол хийлгээгүй, тайлангийн тоон мэдээлэл зөрүүтэй зэргээс харахад “Дүгнэлт бодит бус байна” гэж гүйцэтгэлийн аудитаар үзэж байна.
5. ЗДТГ-ын ХШҮДАХ нь Худалдан авах ажиллагааг зохих журам, зааврын дагуу үнэн зөв тайлагнасан эсэхэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.
6. Аймгийн 2017-2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрт “2017 онд авто замын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх” гэж заасан ч уг төлөвлөгөөний хугацаа 2016 онд дууссан, дахин боловсруулаагүй байна. Үүний улмаас замын сангийн хөрөнгөнөөс хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.
7. Төсвийн ерөнхий менежер буюу ЗДТГ-ын дарга нь худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилтэд хяналт тавих эрхээ бусдад шилжүүлээгүй байхад ОНӨГазар захиалагчийн хяналтын зарим чиг үүргийг хэрэгжүүлэн, захиалагчийн хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна. Мөн захиалагчийн хяналтын зардлыг зарцуулах тодорхой журам, зааваргүйгээс дээрх зөрчил гарах нөхцөл бий болсон байна.

<sup>17</sup> Холбогдох байгууллага, албан тушаалтан алдаа, зөрчлөө хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаа мэдэгдсэн тул зөрчилд акт тогтоогоогүй, албан шаардлага өгөөгүй болно.

<sup>18</sup> МУ-ын Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.5.-д Худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланг дотоод аудит (дотоод аудитын нэгжгүй байгууллагын хувьд өөрийн байгууллагын дотоод аудитор)-аар хянуулж, холбогдох дүгнэлтийн хамт ирүүлнэ.

## **ЗӨВЛӨМЖ**

**Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:**

### **Аймгийн ИТХ-ын дарга Л.Төмөрбаатар-т:**

1. Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт тусгагдаагүй, ТЭЗҮ, зураг, төсөв хийгдээгүй төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэхгүй, батлахгүй байх.

### **Аймгийн Засаг дарга Л.Ганболд-д:**

1. Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт тусгагдсан, ТЭЗҮ, зураг, төсөв нь хийгдсэн төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын хуралдаанд өргөн мэдүүлж батлуулахад гарсан зөрчлийг арилгах талаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцон ажиллах
2. “Авто замын мастер төлөвлөгөө”-г боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулах.

### **Аймгийн ЗДТГ-ын дарга Х.Ган-Очир-т:**

1. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтийг хангуулах, гэрээний хугацаанд хэрэгжихгүй болсон үед шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ашиглалтад оруулах, хуульд заасан захиалагчийн бүрэн эрхийг бодит утгаар нь хэрэгжүүлж ажиллах.
2. Захиалагчийн хяналтын зардлыг зарцуулах журам боловсруулан батлуулж, зардлыг зориулалтын дагуу үр дүнтэй, үр ашигтай зарцуулах.
3. ЗДТГ-ын ХОХБТХ, ХШҮДАХ, ОНӨГ, СХДАА-ны ажилтан албан хаагчдын ажлын уялдаа холбоог сайжруулж, хариуцлагын арга хэмжээ авч ажиллах

### **Аймгийн ОНӨГ-ын дарга Б.Болд-д**

1. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг үнэн зөв, бодитой тайлагнах, журмын дагуу дотоод аудитын дүгнэлт гаргуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх

### **Аймгийн ЗДТГ-ын дарга ХШҮДАХ-ийн дарга Ч. Уртнасан-д:**

1. МУ-ын Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 4.1. (*Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд журмын 2 дугаар хэвсрэлтээр батлагдсан үнэлгээний аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.*)-ийг хэрэгжүүлж ажиллах

### **Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга В.Нэргүйд:**

1. Худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланд хяналт шалгалт хийж бодит дүгнэлт гаргах, ажлын хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах

Хавсралт 1:

**Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд  
санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний судалгаа**

/сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	2017 оны ХО-ын хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө			ТЭЗҮ хийгдсэн эсэх	Зураг төсөв хийгдсэн эсэх	Гэрээний дүн	2017 онд санхүүжүүлсэн дүн	тайлбар тодруулга
		эхлэх	дуусах	Төсөвт өртөг					
<b>Орон нутгийн хөрөнгө оруулалт</b>									
1	Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэг, засвар үйлчилгээ	2017	2017	30.0	Үгүй	-	29.9	29.9	Бүрэн хэрэгжсэн
2	Төрийн албан хаагчдын техник, хэрэгслийг шинэчлэх	2017	2017	6.5	Үгүй	-	6.5	6.5	Бүрэн хэрэгжсэн
3	Баянзүрх сумын дотуур байрны барилгын засварын ажил	2017	2017	68.0	Үгүй	Тийм	67.4	67.4	Бүрэн хэрэгжсэн
4	Багийн эмч, багийн дарга, цагдааг унаажуулах	2017	2017	52.4	Тийм	-	52.4	52.4	Бүрэн хэрэгжсэн
5	Малын хулгайтай тэмцэх тасагт тоног төхөөрөмж	2017	2017	9.2	Үгүй	-	9.2	9.2	Бүрэн хэрэгжсэн
6	Зураг төсвийн зардал	2017	2017	189.09	Үгүй	-	106.44	102.14	
7	RO ус цэвэршүүлэх систем худалдан авах, байршуулах /Нэгдсэн эмнэлэг/	2017	2017	30.0	Тийм	-	29.9	29.9	Бүрэн хэрэгжсэн
8	Засварын зардал /Нэгдсэн эмнэлэг/	2017	2017	3.0	Тийм	Тийм	3.0	3.0	Бүрэн хэрэгжсэн
9	Фото альбом хэвлүүлэх /аймгийн/	2017	2018	30.0	Үгүй	-	8.0	6.4	Хэрэгжээгүй. Гэрээний хугацаа дууссан. Гэрээнд сунгалт хийгээгүй.
10	Чулууны үйлдвэр байгуулах /аймгийн ЗДТГ/	2017	2018	403.47	Үгүй	Тийм	377.59	204.94	Гэрээний хугацаа дуусаагүй байгаа. /Барилгын ажил дуусаагүй, тоног төхөөрөмж авсан/
11	Багийн ЗД, багийн эмчийн мотоцикль /сумдад/	2017	2017	60.0	Тийм	-	59.84	59.84	Бүрэн хэрэгжсэн
12	Соёмбо танхимын их засвар /АЗДТГ/	2017	2018	248.84	Үгүй	Тийм	236.25	100.0	Бүрэн хэрэгжсэн

13	Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулах	2017	2017	10.0	Үгүй	-	10.0	7.0	Хэрэгжээгүй. Гэрээний хугацаа дууссан. Гэрээнд сунгалт хийгээгүй.
14	Бензин бага зарцуулдаг машин худалдаж авах /МХГ/	2017	2017	10.0	Тийм	-	10.0	10.0	Бүрэн хэрэгжсэн
15	Зүрхний эхо аппаратын засвар /Нэгдсэн эмнэлэг/	2017	2017	12.5	Тийм	-	10.9	10.9	Бүрэн хэрэгжсэн
16	Соёлын төвийн барилгын засварын ажил /Хатгал тосгон/	2017	2017	30.0	Үгүй	Тийм	7.52	7.36	Бүрэн хэрэгжсэн
17	Барилгын гадна дулааны ажил /ОБГ/	2017	2018	159.0	Үгүй	Тийм	109.7	29.0	Бүрэн хэрэгжсэн
18	Орон сууцны байруудын хэрэглээний халуун усны шугамыг өргөтгөх	2017	2018	51.67	Үгүй	Тийм	51.6	10.85	Хэрэгжиж байгаа. Гэрээний хугацааг сунгасан.
19	Өрхийн эмнэлгийн дээврийн засвар /Далайн элбэрэл/	2017	2017	5.0	Үгүй	Тийм	5.0	4.7	Бүрэн хэрэгжсэн
20	Хүүхдийн цэцэрлэгийн барилгыг засварлах ажлыг дуусгах /Төмөрбулаг сум/	2017	2017	25.0	Үгүй	Тийм	23.92	8.6	Бүрэн хэрэгжсэн ч зөрчил, дутагдалтай.
21	ЭМТ-н барилгын засвар /Тосонцэнгэл сум/	2017	2017	60.0	Үгүй	Тийм	51.9	50.95	Бүрэн хэрэгжсэн.
22	Ахмадын өргөөний барилга барих /Галт сум/	2017	2018	192.11	Үгүй	Тийм	174.0	146.0	Бүрэн хэрэгжсэн.
23	Соёл, спортын төвийн барилга шинээр барих /Жаргалант сум/	2017	2018	3298.0	Үгүй	Тийм	3298.0	135.0	Гэрээний хугацаа дуусаагүй.
24	Спорт заалны барилга шинээр барих /Эрдэнэбулган сум/	2017	2018	250.0	Үгүй	Тийм	214.68	100.0	Гэрээний хугацаа дуусаагүй.
25	Хилийн заставт ажилладаг ажилчдын хүүхдийн СӨБ-ын сургалтад хэрэглэгдэх хэрэглэгдэхүүний зардал /8 заставт/	2017	2017	8.0	Үгүй	-	8.0	8.0	Бүрэн хэрэгжсэн.
26	Аймгийн нэгдсэн эмнэлгийн амбулаторын барилгын засварын дуусгалтын ажил	2017	2018	207.0	Тийм	Тийм	125.99	0	Бүрэн хэрэгжсэн
27	ХХҮГ-ын харьяа Эрчим ахмадын амралт сувиллын засвар, өргөтгөлийн ажлын дуусгалт /Хатгал тосгон/	2017	2018	300.0	Үгүй	Тийм	651.28	0	Гэрээний хугацааг сунгасан.
	Нийт дүн			5731.8			5738.91	1199.98	

Аймгийн замын сангийн хөрөнгөөр хийх төсөл, арга хэмжээ									
1	Мөрөн сумын 4-н замын 2 уулзварт гэрлэн дохио суурилуулах	2017	2017	112.0	Тийм	Тийм	83.08	83.08	Бүрэн хэрэгжсэн
2	Мөрөн сумын төв 4 зам, аюулгүйн тойргийн 4 замын уулзварын гэрлэн дохио засварлах ажил	2017	2017	16.5	Тийм	-	16.21	16.21	Бүрэн хэрэгжсэн
3	Замын хяналтын камерын засварын ажил	2017	2017	4.2	Тийм	-	4.18	4.18	Бүрэн хэрэгжсэн
4	Мөрөн суман дахь автомашины зогсоолын талбайн зураг төсөв, богино холбоосын зам барих ажлын зураг төсөв	2017	2017	47.6	Тийм	-	47.6	47.6	Бүрэн хэрэгжсэн.
5	50 100 цогцолборын хайрган хучилттай замын траст орсон шилэн кабелиг шилжүүлэх	2017	2017	6.0	Тийм	Тийм	6.0	6.0	Бүрэн хэрэгжсэн
6	Мөрөн сумын 9-р багийн хатуу хучилттай авто замын уулзварыг өргөтгөх ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	2017	2017	0.7	Тийм	-	0.69	0.69	Бүрэн хэрэгжсэн.
7	Зураг төсвийн зардал /Улаан-Уул сумын Тоомын даваа, Ренчинлхүмбэ сумын Сантын гүүр, Жиглэг, Сантын даваа/	2017	2017	23.5	Тийм	-	23.5	23.5	Бүрэн хэрэгжсэн.
8	Хот тохижилт үйлчилгээний замын арчилгааны давс, цас хайлуулах бодис багаж тоног төхөөрөмж худалдан авах	2017	2017	9.0	Тийм	-	9.0	9.0	Бүрэн хэрэгжсэн.
9	Мөрөн сумын 1-р багийн авто зам дагуу гудамжны ус зайлуулах байгууламж барих	2016	2017	56.0	Тийм	Тийм	55.99	55.03	Бүрэн хэрэгжсэн. 2 хоолой хийгдсэн ба 2017 онд 1 хоолой хийгдсэн.
10	Мөрөн сумын 6. 12-р багийн авто замын барилгын ажил	2017	2018	688.54	Тийм	Тийм	630.12	167.1	Гэрээний хугацаа дуусаагүй.
11	Чандмань-Өндөр сумын Улаан-Асга багийн Булнай рашаан хэсэгчилсэн авто замын засварын ажил	2017	2018	79.99	Тийм	Тийм	78.0	19.96	Бүрэн хэрэгжсэн.
12	Тариалангийн Шивэртийн давааны зам засвар	2017	2017	5.0	Тийм	Тийм	5.0	5.0	Бүрэн хэрэгжсэн.
13	Түнэл сумын Хасагийн дөрөлжийн давааны зам засвар	2017	2017	5.0	Тийм	Тийм	5.0	5.0	Бүрэн хэрэгжсэн.
14	Замын сангийн нөөц	2017	2017	10.0	-	-	2.9	2.9	
15	Замын сангийн нөөц	2017	2017	20.0	-	-	2.06	2.06	
	Нийт дүн			1084.03			960.27	447.31	

“Орон нутгийн 2017 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр ашиг”  
гүйцэтгэлийн аудитын хураангуй тайлан

Огноо: 2018.05.09

**Нэг. Ерөнхий мэдээлэл**

Аудитын код:	ГАГ-ХӨА-2018-01-ГА	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Хөвсгөл аймгийн ЗДТГ, ОНӨГ, МХГ, ГХБХБГ
Аудитын нэр:	“Орон нутгийн 2017 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр ашиг”		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Тэргүүлэх аудитор О.Ганболд, Аудитын менежер Г.Эрдэнэчимэг, Ахлах аудитор Ж.Отгончимэг, Аудитор Б.Сандуйжав

**Хоёр. Аудитын үр дүн:**

2.1 Аудитын зорилго, хамарсан хүрээ:

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж дүгнэлт, зөвлөмж боловсруулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт үндэслэлтэй оновчтой байна уу?

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа үр дүнтэй байна уу?

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн ИТХ, ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ, ОНӨГ, МХГ, ГХБХБГ, сумдын ИТХ болон ЗДТГ, холбогдох байгууллагууд, зарим гүйцэтгэгч ААН-ийн хүрээнд шалгалаа.

2.2.1 Гол асуулт / аудитын дэд зорилт 1:

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хуулийн шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн үү?

Хариулт 1:

- Бодлогын баримт бичигт тусгагдаагүй төсөл, арга хэмжээг баталсан. /Нийт 512.6 сая төгрөг/
- ТЭЗҮ хийгдээгүй төсөл, арга хэмжээг баталсан. /Нийт 5373.9 сая төгрөг/
- Зураг төсөв нь аймгийн ИТХ-ын тогтоолын дараа хийгдсэн. /Нийт 4214.1 сая төгрөг/

- Хөрөнгийн шинж чанар агуулаагүй болон улсын төсвийн байгууллагад хөрөнгө оруулалт хийх төсөл, арга хэмжээг баталсан. /Нийт 226.0 сая төгрөг/

2.2.2 Гол асуулт / аудитын дэд зорилт 2:

Худалдан авах ажиллагаа хуулийн дагуу явагдсан уу?

Хариулт 2:

Худалдан авах ажиллагааг үнэн зөв, бодитой тайлагнаагүй, үүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.



2.2.3 Гол асуулт / аудитын дэд зорилт 3:

Захиалагчийн хяналт үр нөлөөтэй хэрэгжсэн үү?

Хариулт 3:

- Захиалагчийн хяналтын зардлыг зориулалт бус зарцуулсан. /Нийт 32.9 сая төгрөг/
- Төсөл, арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээний хугацаа дууссан ч ажил нь дуусаагүй, захиалагч ямар нэгэн арга хэмжээ аваагүй.

## 2.3 Аудитын гол дүгнэлт

TAX-г төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаалан төсвийн хөрөнгө үр дүн, үр ашиггүй зарцуулагдах нөхцлийг бий болгож, улмаар зөрчлүүд жил бүр давтагдан гардаг болжээ.

## 2.4 Аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс			
		Тоо	Дүн /сая төгрөг/	Зөвлөмж	Төлбөрийн акт	Албан шаардлага	Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
A	1	2	3	4	5	6	7
1	Аймгийн ЗДТГ, ОНӨГ	6	10359.5	10359.5			
2	Төслийн менежерийн баг	2	18.0			18.0	
	ДҮН		10377.5	10359.5		18.0	

### Гурав. Баталгаажуулалт

Тайлангийн хураангуй бэлтгэсэн: Ахлах аудитор  
Аудитор

Ж.Отгончимэг  
Б.Сандуйжав

Чанарын хяналт хийсэн: Аудитын менежер  
Танилцаж зөвшөөрсөн: Дарга, тэргүүлэх аудитор

Г.Эрдэнэчимэг  
О.Ганболд

### Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018.05.09	Аудитын нэр:	“Орон нутгийн 2017 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр ашиг”	Аудитын код:	ГАГ-ХӨА-2018/01/-ГА
Шалгагдсан байгууллагын нэр:		Аймгийн ИТХ, ЗДТГ, ОНӨГ, ГХБХБГ, МХГ сумдын ИТХ, ЗДТГ			Сая төгрөгөөр

№	Аудитын зорилт чиглэл	Тоо	Аудитын зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
1	Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.	1	Бодлогын баримт бичигт тусгагдаагүй төсөл, арга хэмжээг баталсан	512.6	Зөвлөмж	2018.05.09	A/20	ИТХ-н дарга	Л.Төмөрбаатар
2		1	ТЭЗҮ хийгдээгүй төсөл, арга хэмжээг баталсан.	5373.9	Зөвлөмж	2018.05.09	A/20		
3		1	Зураг төсөв нь аймгийн ИТХ-ын тогтоолын дараа хийгдсэн.	4214.1	Зөвлөмж	2018.05.09	A/20		
4		1	Хөрөнгийн шинж чанар агуулаагүй болон улсын төсвийн байгууллагад хөрөнгө оруулалт хийх төсөл, арга хэмжээг баталсан.	226.0	Зөвлөмж	2018.05.09	A/20	Засаг дарга	Л.Ганболд
5		1	Худалдан авах ажиллагааг үнэн зөв, бодитой тайлагнаагүй, үүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.	0	Зөвлөмж	2018.05.09	A/20	ОНӨГ-н дарга	Б.Болд
6		1	Захиалагчийн хяналтын зардлыг зориулалт бус	32.9	Зөвлөмж	2018.05.09	A/20	Засаг дарга	Л.Ганболд

			зарцуулсан						
7		1	Төсөл, арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээний хугацаа дууссан ч ажил нь дуусаагүй, захиалагч ямар нэгэн арга хэмжээ аваагүй.	0	Зөвлөмж	2018.05 .09	A/20	ЗДТГ-н дарга	Х.Ган-Очир
8		2	Гэрээний хугацаанд төсөл, арга хэмжээг хэрэгжүүлээгүй.	18.0	Албан шаардлага	2018.05 .11	01/21, 02/22	ЗДТГ-н ТЗУХ-н дарга, ЗДТГ-н ХОХБТХ-н мэргэжилтэн	Х.Цэнд-Аюуш Г.Энхбаяр
<b>Нийт дүн</b>				<b>10377.5</b>					

Бэлтгэсэн: Ахлах аудитор  
Аудитор

Ж.Отгончимэг  
Б.Сандуйжав

ОГНОО:  
ОГНОО:

Анхан шатанд хянасан: Аудитын менежер  
Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор

Г.Эрдэнэчимэг  
О.Ганболд

ОГНОО:  
ОГНОО:

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал

Хөвсгөл аймаг дахь Төрийн  
аудитын газрын тайлбар

Аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн санал

  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

67123, Мөрөн, Хөвсгөл аймаг

Утас, факс: 70382929

Э-мэйл: khovsgol@state.audit.mn

2018.05.04 № 4/06



танилцсан \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

"Орон нутгийн 2017 оны хөрөнгө оруулалтын үр  
дүн, үр ашиг" гүйцэтгэлийн аудитын тайлангийн  
төсөлтэй танилцлаа.

Тусгайлан гаргах санал байхгүй байгаа болно.

ДАРГА  Н.БЯМБАДОРЖ

  
ТАТГ 

D:\Documents \root\

Гүйцэтгэлийн аудитын тайлангийн  
дүн, дүгнэлт, зөвлөмжтэй санал нэг  
байна гэж үзэв.

Аймгийн ОНӨГ-аас ирүүлсэн санал



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗАР**

87121, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Үүндэнэ бэй  
АЗДИГ-ын байр А корпус 1 дундур  
Утас: 7038 8849; 70388821, факс: 70388848  
Э-хөвч: khuvsgul-tender@khs.gov.mn  
Вэбсайт: http://umcti.khs.gov.mn

2018.05.04 № 1/485  
танай 2018.05.02-ны № 05/524 -с

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.ГАНБОЛД ТАНАА**

“Орон нутгийн 2017 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийн дүгнэлт хэсгийн 7 дахь, зөвлөмж хэсгийн “Орон нутгийн өмчийн газар”-т зөвлөсөн хэсгүүдтэй тус тус санал нийлж байна.

Уг тайлангийн төслийн дүгнэлт, зөвлөмжид дурьдагдсан зөрчил, дутагдлыг заасан хугацаанд арилгаж, тухай бүр тайлагнаж ажиллана.

Аудитын тайлангийн төслийг хавсаргав.



ДАРГА

Б.БОЛД



Андаа ол.Оогон

ГА-ны тайланг  
оваах О.Г.

Ф/А/5

Гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүн, дүгнэлт, зөвлөмжтэй санал нэг байна гэж үзэв.

Аймгийн Засаг даргаас ирүүлсэн санал

 <p>ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.ГАНБОЛД ТАНАА</p> <p>МОНГОЛ УЛС ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА</p> <p>87123 Мөрөн Хөвсгөл аймэг Утас: 70382300, факс: 70381001 www.khuvsgol.gov.mn</p> <p>2018.05.02 № 1/2018 Тайлбар: 2018.05.02 № 60/2018</p> <p>Тайлбар хүргүүлэх тухай</p> <p>2017 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр ашиг-д гүйцэтгэлийн аудит хийгдсэн тайлангийн төсөлтэй танилцаад дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:</p> <p>1. Орон нутгийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудаас аймгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан зорилт арга хэмжээтэй уялдаагүй төлөвлөлт хийгдсэн 12 ажлын санал<sup>19</sup> ирүүлсэн байна.</p> <p>Дээрхи зөрчил хэмээн тусгагдсан ажлууд нь аймгийн урт хугацааны бодлогын баримт бичиг болох 2016-2030 он хөтөлбөр, засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2017-2020 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичигтэй уялдаж байгаа учир зөрчил гэж үзсэн жагсаалтаас хасуулах саналтай байна. Тайлбарыг хавсралтаар!</p> <p>2. Мөн “зарим төсөл арга хэмжээний магадлашгүй ажлыг олгохдоо Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журмын 4.12-д заасны дагуу олгоогүй байна. Өмнөх оны аудитаар уг зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн боловч биелүүлээгүй гэж үзэн акт тогтоохоор шийдвэрлэсэн байна”.</p> <p>Бид санхүүжилтийг олгохдоо Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, тайлагналтын журмын дагуу олгосон бөгөөд Баянзүрх сумын дотуур байрны барилгын засварын ажлын магадлашгүй ажлыг олгохдоо журмын дагуу магадлашгүй ажлын төсвийг актаар баталгаажуулсан гүйцэтгэлийг үндэслэж олгосон учир акт тогтоохооргүй ажил хэмээн үзэж байна. /Нотлох баримтыг хавсралтаар!</p> <p>3. Захиалагчийн хяналтын зардлаар аймгийн ЗДТГ болон ОНӨГ-т нийт 16,5 сая төгрөгийн тоног төхөөрөмж авсныг нь зөрчил гэж үзсэн байна.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бариа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалтын дагуу улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх холбогдох материалуудын цахим, болон архивын нэгж үүсгэхэд зориулагдсан техник тоног төхөөрөмж худалдан авсан болно.</p> <p>ДАРГА  Л.ГАНБОЛД</p> <p>0112:155</p>	<p>1.Хүснэгт 2-т харуулсан зарим нэгэн арга хэмжээг тайланд тусгасан зөрчлийн дүнгээс хасаж, тайланд өөрчлөлт оруулав.<sup>19</sup></p> <p>2. Мөн “Зарим төсөл арга хэмжээний магадлашгүй ажлын зардлыг олгохдоо Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журмын 4.12-д олгоогүй байна гэсэн саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулав.</p> <p>3.Захиалагчийн хяналтын зардлаар аймгийн ЗДТГ-т болон ОНӨГ-т нийт 16,5 сая төгрөгийн тоног төхөөрөмж авсан нь: Захиалагчийн хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулснаас гадна Санхүүгийн тайлангийн аудитаар МУ-ын ЗГ-ын 2014 оны 147, 2016 оны 47 дугаар тогтоолыг зөрчсөн нь тогтоогдсон тул тайланд өөрчлөлт оруулах боломжгүй гэж үзэв.</p>
---	---

Аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн санал

<sup>19</sup> Зөрчлийн дүнгээс хассан ТАХ-нь 2012-2016 онд хэрэгжүүлэх Авто замын мастер төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд нөхөж хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ байна.



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗАР**

67123, Мөрөн, Хөвсгөл аймаг  
Утас: 70382216  
www.khovsgol.gov.mn

2018.05.08 № 3/928  
тандай 2018.05.04-ны № 05/526 -т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.ГАНБОЛД  
ТАНАА**

2017 оны “Орон нутгийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудит хийгдсэн тайлангийн төсөлтэй танилцаад дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1.Төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилтийг хангуулах, гэрээний хугацаанд хэрэгжихгүй болсон үед шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч, хуулинд заасан өөрийн бүрэн хэрэгжүүлж ажиллах болно.

2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 57-р тогтоолоор захиалагчийн хяналтыг зарцуулах журмыг аймгийн Орон нутгийн өмчийн газраас боловсруулан батлуулсан.

3. Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажилаа хангалттай гүйцэтгэж байгаа болно.

ДАРГА  Х.ГАН-ОЧИР

1253 6

Тайлбар 1,2-ыг Гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүн, дүгнэлт, зөвлөмжтэй санал нэг байна гэж үзэв.

3.ЗДТГ-ын холбогдох хэлтсүүд болон ОНӨГ, СХДАА гэж зөвлөмжид өөрчлөлт оруулав.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг  
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93  
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn  
Вэбсайт: www.audit.mn

2018.05.11

№ ГАГ-ХӨА-2018-01-ГА-01/21

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГАА  
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,  
ТӨСЛИЙН МЕНЕЖЕР  
Х.ЦЭНД-АЮУШ ТАНАА

**Зөрчил арилгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/06 дугаар тушаалын дагуу гүйцэтгэсэн “Орон нутгийн 2017 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд: “Хөвсгөл аймгийн фото альбом хэвлүүлэх ажил”-ыг 8,0 сая төгрөг /Найман сая төгрөг/-өөр 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүлээн авахаар Дугаар №ХӨ-2017/4.5.8-Б/01 тоот “Гэрээ” хийсэн ч гэрээний үүргээ заасан хугацаанд хэрэгжүүлээгүй байна.

Иймд: Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т (... аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх ...) Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.5-д (... байгуулсан гэрээ, хэлцэл мөрдөж байгаа тууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага, нөхцлийн хангаагүй алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө...) гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Дугаар №ХӨ-2017/4.5.8-Б/01 тоот “Гэрээ”-нд заасан 8,0 сая төгрөг /Найман сая төгрөг/-ийн өртөг бүхий бараа / Хөвсгөл аймгийн фото альбом хэвлүүлэх ажил /-г 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хүлээн авч биелэлтийг нотлох баримтын хамт Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга, төслийн менежер Х.Цэнд-Аюуш-т даалгав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

ӨГСӨН:

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын  
Ахлах аудитор *[Signature]* Ж.Отгончимэг  
Аудитор *[Signature]* Б.Сандуйжав

ЗӨВШӨӨРСӨН:

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга,  
төслийн менежер

*[Signature]* Х.Цэнд-Аюуш



<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангаадаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил заргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.





**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

Б7123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг  
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93  
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn  
Вэбсайт: www.audit.mn

26/3.05.11

№ ТАГ-ХӨА-2018-01-ГА-02/22

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН, ТӨСЛИЙН МЕНЕЖЕР  
Г.ЭНХБАЯР ТАНАА

**Зөрчил арилгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалын дагуу гүйцэтгэсэн “Орон нутгийн 2017 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд: “Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулах” ажлыг 10,0 сая төгрөг /Арван сая төгрөг/-өөр 2018 оны 03 дугаар сарын 08-ны өдөр хүлээн авахаар Дугаар №ХӨ-2017/1.2.3-Зөвлөх-01 тоот “Гэрээ” хийсэн ч гэрээний үүргээ заасан хугацаанд хэрэгжүүлээгүй байна.

Иймд: Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-г (... аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх ...) Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.5-д (... байгуулсан гэрээ, хэлцэл мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага, нөхцлийн хангаагүй алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө...) гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

Дугаар №ХӨ-2017/1.2.3-Зөвлөх-01 тоот “Гэрээ”-нд заасан 10,0 сая төгрөг /Арван сая төгрөг/-ийн өртөг бүхий бараа /Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө/-г 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүлээн авч биелэлтийг нотлох баримтын хамт Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн /Төслийн менежер/ Г.Энхбаяр-т даалгав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН<sup>1</sup>:**

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын  
Ахлах аудитор *[Signature]*  
Аудитор *[Signature]*

Ж.Отгончимэг  
Б.Сандуйжав

**ЗӨВШӨӨРСӨН:**

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

*[Signature]*  
Г.Энхбаяр

<sup>1</sup> Акт, албан шаардлагаг биелэлт хангаадаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас төлөсөн албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил заргасан албан тушаалтныг уурст ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж зөвснө дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.